

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны  
санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/1/СТА-ТЭЗ

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	8
2.8.2 Авлага.....	10
2.8.3 Урьдчилгаа .....	13
2.8.4 Бараа материал .....	13
2.8.5 Үндсэн хөрөнгө .....	13
2.8.6 Өр төлбөр .....	16
2.8.7 Засгийн газрын хувь оролцоо.....	17
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	17
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	20
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	21
2.14. Аудитын зөвлөмж.....	21-23
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	26
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	26
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	29
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	34
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	38
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	39
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	

<b>ТЕЗ</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>
<b>ТАБ</b>	Төрийн аудитын байгууллага
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ТЗС</b>	Тусгай зориулалтын сан
<b>БХС</b>	Байгаль хамгаалах сан
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>УСНББОУС</b>	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
<b>НББОУС</b>	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
<b>СТОУС</b>	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>АОУС</b>	Аудитын олон улсын стандарт
<b>СТА</b>	Санхүүгийн тайлангийн аудит
<b>ОНААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНТБ</b>	Орон нутгийн төсвийн байгууллага
<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж байгууллага
<b>ОНӨХХК</b>	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.04.20 № 160

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

006020332

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## **1. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналт, авлага, өглөг, хууль журмын хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үйл ажиллагааны эрхэм зорилго нь аймгийн Засаг даргад өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх замаар нутгийн захиргааны байгууллагуудын үр дүнтэй хэвийн үйл ажиллагааг хангаж, мэргэшсэн тогтвортой албаар иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймаг, нийслэл, хотын таван жилийн үндсэн чиглэл, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах;
- Нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах;

Төсвийн тухай хуулиар аймгийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичгийг 2020 онд боловсруулан аймгийн Засаг даргын А/424 дугаар тушаалаар баталсан байна.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт 17 арга хэмжээ тусгагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг тооцоход үр дүнтэй 16, үнэлэх боломжгүй 1 заалт буюу бүрэн хэрэгжсэн гэж үзжээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд Шилэн дансны 2019 оны тайлан, 2020 оны хагас жилийн тайлан, аймгийн Нөөцийн газар, “Шинэ хөдөө-Хөгжил” ОНӨААТҮГ-Т хийсэн хяналт шалгалтын дүнг тус тус хэлэлцүүлсэн байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаа батлуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд дотоод хяналт шалгалтаар нийт 81 актаар 60.1 сая төгрөгийн төлбөр тогтоож, 39.7 сая төгрөгийн 23 албан шаардлага хүргүүлж албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Өмнөх оны актын үлдэгдэл 43.1 сая төгрөг үүнээс хуулийн байгууллагад 13.9 сая төгрөг, тайлант оны актын үлдэгдэл 21.2 сая төгрөг байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 76425.4 сая төгрөгийн 2 хувь буюу 1528.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны санхүүгийн тайлангийн нийт зардлаас төлөвлөлтийн шатанд тогтоосон хувь хэмжээгээр тооцон 84808.2 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 1696.1 сая төгрөгөөр тогтоолоо.

## 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкнуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансны үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 6707.6 сая, жилийн эцэст 9823.7 сая төгрөг болж, 3116.1 сая төгрөгөөр буюу 46.5 хувиар өссөн байна.

2020 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 98.2 хувь буюу 9643.1 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 1.8 хувь буюу 176.1 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 0.0.4 хувь буюу 4.4 сая төгрөг нь байгууллагуудын кассад байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн өсөлт, бууралтыг хүснэгтээр харуулбал

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Кассад байгаа бэлэн мөнгө	2.8	4.40	4.4		
Төрийн сангийн харилцах	6093.5	9643.10			9643.10
Арилжааны банк	611	176.06		176.1	
Замд яваа мөнгө	0.3	0.15			
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>6707.6</b>	<b>9823.7</b>	<b>4.4</b>	<b>176.1</b>	<b>9643.10</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>					
Төрийн сан	3698.25	7109.5			7109.5
Төсөвт байгууллага	2316.92	2420.1		2.8	2417.3
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	613.98	177.8	4.4	173.3	
Төсөл сангууд	78.44	116.3			116.3
<b>Дүн</b>	<b>6707.6</b>	<b>9823.7</b>	<b>4.4</b>	<b>176.1</b>	<b>9643.1</b>

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Кассын үлдэгдэл 4.4 сая төгрөгийн 1.8 сая төгрөг нь “Илчит-Хутаг” ОНӨААТҮГ, 1.5 сая төгрөг нь “Ахмадын сан”-гийн, 0.9 сая төгрөг нь “Булган-Мээж” ОНӨХХК, 0.7 сая төгрөг нь “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын газруудын үлдэгдэл байна.

Арилжааны банкны үлдэгдэл 176.1 сая төгрөгийн 1.1 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 174.9 сая төгрөг нь орон нутгийн өмчит газрын дансны үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.15 сая төгрөг нь “Булган-Мээж” ОНӨХХК-ий мөнгөн хөрөнгө байна.

#### **Төрийн сангийн мөнгөн хөрөнгө**

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6093.5 сая, эцсийн үлдэгдэл 9643.1 сая төгрөг болж 3549.6 сая төгрөгөөр өссөн байна. Төрийн сангийн дансанд байршиж буй 9643.1 сая төгрөгийн үлэгдлээс 7109.5 сая төгрөг нь аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 2417.3 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 116.3 сая төгрөг нь төсөл сангийн дансны үлдэгдлүүд байна.

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 2925.3 сая төгрөгийг зарцуулахаар төсөвт тусгаж батлуулснаас сумын ИТХ, ЗДТГ-ын үйл ажиллагаанд дутагдаж буй зарим зардлыг тухайлбал хичээл практик, урсгал засвар, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж бэлтгэх зэрэгт 433.2 сая, аймаг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнд 127.6 сая, хөрөнгө оруулалтад 1075.2 сая, сум баг хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, мал хамгаалах сангийн зээл олголтод 886.3 сая, байгаль хамгаалах сан, гамшгаас хамгаалах сангаас 348.8 сая төгрөгийг тус тус зарцуулахаар батлуулсан байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 9823.7 сая төгрөг нь аймгийн төсвийн ерөнхий орлогын дансанд 5598.8, сумдын төсвийн ерөнхий орлогын дансанд 1510.7, сум хөгжүүлэх сангийн дансанд 797.8, аймгийн ОНХС-гийн дансанд 1.6, сумын ОНХС-гийн дансанд 502.5, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд 461.5, аймгийн байгаль хамгаалах сангийн дансанд 19.0, сумдын байгаль хамгаалах сангийн дансанд 568.7, мал хамгаалах сангийн дансанд 81.5, ЖДҮДС дансанд 92.0, орон нутгийн өмчит газруудын дансанд 177.8 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 177.8 сая төгрөгийн 77.6 хувь буюу 137.9 сая төгрөг нь “Булган Мээж” ХХК-ий үлдэгдэл байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- *Хорио цээр тогтоосонтой холбоотой сургалтын үйл ажиллагааг танхимаар хичээллэхийг түр зогсоосон хугацаанд багш ажилчдад хоолны нэмэгдэл олгосон /Булган сумын 1-р сургууль 11.7, 2-р сургууль 11.9, 3-р сургууль 4.5, спортын дунд сургууль 1.9, 2-р цэцэрлэг 5.8, 6-р цэцэрлэг 3.4, 7-р цэцэрлэг 4.3 сая төгрөг*
- *ОНХС-гаас анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна. /Тэшиг сум 0.2, Хялганат тосгоны ОНХС 0.7 сая төгрөг,*
- *Хутаг-Өндөр сумын ЕБС “Түүчээ Намнан” ХХК-иас хийсэн худалдан авалтаас 19212.9 мянган төгрөгийн НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/*
- *“Булган-Мээж” ОНӨХХК шатахуун түгээх “НИК” ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй, Дэл-агт ХХК-нд 1600 л буюу 3232.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу шатахууныг олгосон,*
- *Тайлант хугацаанд худалдан авсан бараа материал, ажил үйлчилгээний анхан шатны баримт нь цахим И баримтаар нотлогдоогүй, /2-р цэцэрлэг 4.9, 3-р цэцэрлэг 6.4, 7-р цэцэрлэг 5.8/*
- *Бэлэн мөнгөний кассын үлдээдлийг 1500.0 мянган төгрөгөөс хэтрүүлэхгүй байх, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг хийхээс бусад үед банкны харилцах дансаар гүйлгээг хийх. / “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ /*

- Жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтын бүрдэл дутуу шатахуун олгосон, /Бүрээхангай сумын ЗДТГ 1.2, Дашинчилэн сумын ЗДТГ 3.4,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй, /Бугат сумын ЗДТГ 5.0, Сайхан сумын ЗДТГ 11.7, Сэлэнгэ сумын ЗДТГ 1.4/

## 2.8.2 Авлага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 5517.6 сая төгрөг оны эцэст 7615.2 сая төгрөгөөр тайлагнаж, өмнөх оноос 2097.7 сая төгрөгөөр өссөн байна.

### Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, ангиллаар нь харуулбал

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+ ) бууралт (- )	Хувь
Ажилчидтай холбоотой авлага	10.78	16.4	5.62	0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	6.93		-6.93	0.0
Зээлийн хүүгийн авлага	34.06	28.8	-5.26	0.4
Дансны авлага /ТӨҮГ/	0.57	1259.1	1258.53	18.1
Татвар НДШ-ын авлага /ТӨҮГ/	4.47	0.36	-4.11	0.0
Байгууллагаас авах авлага	876.53	987.2	110.67	14.2
Хувь хүнээс авах авлага	4402.4	4465.7	63.3	64.4
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	181.83	181.8	-0.03	2.6
<b>Нийт дүн</b>	<b>5517.57</b>	<b>6939.4</b>	<b>1421.8</b>	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр:				
Төсөвт байгууллага	5026.99	5020.6	6.4	72.3
Төсөл/сан	48.02	162.6	114.59	2.3
Төрийн сан	214.42	225.2	10.73	3.2
ОНӨГ	228.14	1531.0	1302.88	22.1
<b>Нийт дүн</b>	<b>5517.57</b>	<b>6939.4</b>	<b>1421.8</b>	100.0

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 64.4 хувь буюу 4465.7 сая төгрөг нь хувь хүмүүсээс авах авлага, 14.2 хувь буюу 987.2 сая төгрөг нь байгууллагаас авах авлага, 18.1 хувь нь буюу 1259.0 сая төгрөг нь дансны авлага, 2.6 хувь буюу 181.8 сая төгрөг нь засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага байна.

Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 72.3 хувь нь төсөвт байгууллагын, 22.1 хувь нь ОНӨГ-ын, 3.2 хувь нь төрийн сангийн, 2.3 хувь нь төсөл сангийн авлага байна.

Өмнөх оноос авлага 1421.8 сая төгрөгөөр өссөн нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагын цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдан авах гэрээ байгуулан төлбөрөө төлсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж тоглоом нийлүүлэх хугацаа тодорхойгүй хугацаагаар хойшилсон шалтгаанаар 22 цэцэрлэгтэй холбоотой 176.8 сая төгрөгийн авлага үүссэн,

“Шинэ-хөдөө хөгжил” ОНӨААТҮГ нь шинээр байгуулагдаж 2017-2019 онуудад “Шинэ-хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн болон байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх нөхцөлөөр олгогдсон төсөл арга хэмжээний 1259.1 сая төгрөгийн хөрөнгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

### **Төрийн сангийн авлага:**

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 181.8 сая төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- 1997 онд үүссэн “Баялаг” компанитай холбоотой аймгийн нөөц барааны үлдэгдэл үнэ 1198.6, ОК-ийн шугамаар ирсэн тэжээлийн хивгийн үнэ 1171.0 мянган төгрөгийн авлага, одоогоор уг компани байхгүй эзэн холбогдогчгүй,
- 1997 онд үүссэн Спиртийн үйлдвэрт олгосон зээлийн үлдэгдэл 11.4 сая төгрөгийн авлага,
- 1998 онд үүссэн “Чин хоршоо”-нд бөөний худалдаа дэмжих зорилгоор олгосон 1.6 сая төгрөгийн зээлийн авлага,
- 1998 онд “Материал импекс” ХХК-тай холбоотой 0.5 сая төгрөгийн авлага,
- 1999 онд үүссэн “ХОТШ” банкттай холбоотой 0.5 сая төгрөгийн авлага,
- 1999 онд үүссэн “Царс-Импекс” ХХК-иас татварын өрөнд авсан нүүрсийг дамжуулж өгөхдөө дутуу өгсөн 11.4 сая төгрөгийн авлага,
- 1999 онд үүссэн “СОНУ” ХХК-тай холбоотой, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгөнөөс хийгдээгүй ажлын санхүүжилт гэж аймгийн татааснаас суутгаж авсан 12.28 сая төгрөгийн авлага,
- ЭТНО зээл 1993 онд үүссэн 2.7 сая төгрөгийн авлага,
- НХ-ийн төв 1999 онд үүссэн Бүрэгхангай сумын нийгмийн ажилтан байсан н.Оюумаагаас төсөвт төвлөрүүлэх төлбөр,
- Өвсний авлага 2001 онд үүссэн 1149.1 сая төгрөгийн авлага,

Дээрх авлагын барагдуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн, аймгийн ЗДТГ-ын СТСХ Булган аймгийн Шүүхийн тамгын газарт 44.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах боломж байгаа эсэх талаар бичиг хүргүүлсэн боловч хүлээн авах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Олон жилийн насжилттай хувь хүнээс болон байгууллагаас авах авлагуудын эзэн холбогдогчид нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхойгүйгээс шүүхэд хандах боломжгүй бол зарим нь хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон найдваргүй авлагууд байна.

Мөн 2008 онд үүссэн “Атрын III” аяны хүрээнд олгогдсон зээлээс Баяннуур сумын “Эй энд Херба” ХХК 65.1, Сэлэнгэ сумын “Сэлэнгэ бат хоршоо” 4.9, Хангал сумын “Эрх” ХХК 40.0, Хутаг-Өндөр сумын “Хутаг цахиур” ХХК 23.4, Тэшиг сумын Г.Оюунцэцэг 4.0 сая төгрөг нийт 137.39 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулаагүй байна.

### **Сум хөгжүүлэх сангийн авлага:**

Төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-гаас олгосон зээлтэй холбоотой үүссэн авлагын эхний үлдэгдэл 4200.4 сая төгрөг 2020 онд 165 иргэнд 1024.2 сая төгрөгийг зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл 4228.7 сая төгрөг үүнээс 559 иргэн, ААНБ-тай холбоотой 1863.1 сая төгрөг нь хугацаа хэтрэлттэй байгаа нь СХС-гийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, үр өгөөжийг бууруулсан байна.

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг сумдаар нь харуулбал:

*Хүснэгт № 5 Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Д/д	Сумын нэр	Нийт зээлийн үлдэгдэл		Хэвийн зээлдэгчийн үлдэгдэл		Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зээлдэгч		Шийдвэр лэсэн байдал 2020
		Иргэдийн тоо	Дүн	Иргэдийн тоо	Дүн	Иргэдийн тоо	Дүн	Иргэдийн тоо	Дүн	
1	Баян-Агт сум	51	198.12	21	58.78	30	139.35	8	56.91	1.14
2	Баяннуур сум	49	181.19	30	123.72	19	57.47	19	57.47	28.17
3	Бугат сум	45	184.98	18	82.57	27	102.41	11	72.01	7.10
4	Булган сум	146	960.83	89	477.58	57	483.25	57	483.25	130.24
5	Бүрэгхангай сум	33	171.91	8	85.37	25	86.54	7	27.62	3.08
6	Гурванбулаг сум	98	219.37	37	144.77	61	74.60	9	19.44	5.01
7	Дашинчилэн сум	48	197.99	42	183.93	6	14.06	-	-	-
8	Могод сум	29	146.41	16	82.91	13	63.50	12	61.35	9.60
9	Орхон сум	109	361.49	59	239.18	50	122.31	50	122.31	26.37
10	Рашаант сум	64	224.74	33	113.60	31	111.14	19	73.49	16.31
11	Сайхан сум	79	270.83	17	125.21	62	145.62	20	46.45	3.21
12	Сэлэнгэ сум	50	186.13	24	81.10	26	105.04	18	74.06	12.51
13	тэшиг сум	74	200.08	7	59.36	67	140.73	67	140.73	52.48
14	Хангал сум	103	277.42	64	196.27	39	81.14	10	50.40	2.60
15	Хишиг-Өндөр сум	41	210.82	30	180.14	11	30.7	8	44.13	31.35
16	Хутаг-Өндөр сум	75	236.35	40	131.05	35	105.30	21	60.79	20.97
17	Нийт дүн	1,094	4,228.67	535	2,365.54	559	1,863.13	336	1,390.40	350.15

*Эх сурвалж: Сумдын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлан*

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг бууруулах талаар өмнөх онд зөвлөмжийг хүргүүлснээр хугацаа хэтрэлттэй 1390.4 сая төгрөгийн зээлийг хуулийн байгууллагад шилжүүлж үүнээс 2020 онд 350.1 сая төгрөгийн төлөлт хийгдсэн, эргэн төлөлтийг эрчимжүүлж сангийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Булган сумын ойн анги талбай тусгаарлалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс 22 цэцэрлэгтэй холбоотой 176.8 сая төгрөгийн авлага үүссэн,
- Өмнөх оны тайланд ХХОАТ-ын 38.9 мянган төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, /Гурванбулаг сумын сургууль, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/
- Оны эхний үлдэгдэл 0.7 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй /Хишиг-Өндөр сумын сургууль/
- Дашинчилэн сумын ЭМТ илүү шилжүүлсэн эмийн зардлыг авлагаар бүртгээгүй,
- Гурванбулаг ЭМТ хүнсний материалыг орлогод аваагүй, харилцагч байгууллага руу 0.4 сая төгрөгөөр илүү шилжүүлж тус тус авлагаар тусгаагүй,

### 2.8.3 Урьдчилгаа:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

### 2.8.4. БАРАА МАТЕРИАЛ:

ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 6317.85 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7019.35 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 701.5 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын үлдэгдлийг нэр төрлөөр нь харуулбал:

Хүснэгт № 6 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+ ) бууралт (- )	Хувь
Тусгай зориулалтын материал	833.75	658.3	-175.45	5.0
Эм боох материал	432.41	346.0	-86.41	2.6
Бэлэн бүтээгдэхүүн	35.33	61.0	25.67	0.5
Бичиг хэргийн материал	180.01	195.2	15.19	1.5
Аж ахуйн материал	2667.13	9521.8	6854.67	71.7
Сэлбэг хэрэгсэл	128.36	130.0	1.64	1.0
Түлш, шатах тослох материал	152.65	85.7	-66.95	0.6
Барилгын засварын материал	122.51	144.3	21.79	1.1
Хүнсний материал	401.15	210.0	-191.15	1.6
Бусад хангамжийн материал	1,721.31	1,636.70	-84.61	12.3
Мал амьтад	344.74	298.1	-46.64	2.2
Нөөцийн бараа			0	0.0
<b>ДҮН</b>	<b>7019.35</b>	<b>13287.1</b>	<b>6267.8</b>	<b>100.0</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	6161.82	5922.8	-239.02	44.6
Төсөл сан	0.42	0.04	-0.38	0.0
ОНӨҮГ	857.11	7364.3	6507.19	55.4
<b>ДҮН</b>	<b>7019.35</b>	<b>13287.1</b>	<b>6267.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 44.6 хувь буюу 5922.8 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 0.01 хувь буюу 0.04 сая төгрөг нь төсөл сангийн, 55.4 хувь 7364.3 сая төгрөг нь ОНӨҮГ газрын бараа материал тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 13138.7, хандив тусламжаар 187.5, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 358.1, бусад эх үүсвэрээс 368.3 сая төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 6466.4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 767.2, бусад болон акталж устгасан 551.3 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж 13287.1 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 6267.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Бараа материалын үлдэгдэл 6267.8 сая төгрөгөөр өссөн нь “Булган- Мээж” ОНӨХХК нь аймагт шинээр баригдсан цэвэрлэх байгууламжийн 6696.9 сая

төгрөгийг хөрөнгийг аж ахуйн материалын дансанд тайлагнаснаас шалтгаалсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Булган сумын 1-р сургууль аж ахуйн материалын дансанд Кабинетын тохижилт 2991.8, Кабинетын хэрэглэгдэхүүн 1795.1 мянган төгрөгийг бөөнөөр нь орлогод авсан материалын нэр төрөл тодорхойгүй, Хишиг-өндөр сумын сургууль аж ахуйн материалын данснаас урсгал засвар гэж 3.1 сая төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр зарлага болгосон,
- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн /Булган сумын 3-р сургууль 8 ширхэг 1360.0 мянган төгрөгийн ширээ сандал бүртгэлтэй, Хутаг-Өндөр сумын сургууль 11.6 сая төгрөг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/
- Эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгараагүй компаниас эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хийсэн, /Баяннуур сумын ЭМТ 1.2, Дашинчилэн сумын ЭМТ 0.2, Гурванбулаг сумын ЭМТ 2.4, Бүрэгхангай сумын ЭМТ 7.4 сая төгрөг/
- БТСГ 4.9 сая төгрөгийн бараа материалыг хүлээж аваагүй байхад орлогоор бүртгэсэн,
- 2020 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллогын бүртгэл, тооллого хийсэн хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр байхгүй, тооллогын баримт материал дутуу /Булган аймгийн Нөөцийн газар, Баян-Агт сумын ЭМТ, Бугат сумын ЭМТ, Сэлэнгэ сумын ЭМТ, Тэшиг сумын ЭМТ 62.6 сая төгрөг,/
- Хүүхдийн хоолны материалыг ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлэн тендер зохион байгуулаагүй. /Дашинчилэн сумын цэцэрлэг, Баян-Агт сумын цэцэрлэг/
- Рашаант сумын сургууль бараа материалын 4 дансны 1128.8 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгээгүй,
- Хишиг-Өндөр сумын сургууль санхүүгийн тайлангаар туслах аж ахуйн мал жилийн эцэст 264 толгой малтай гэвч малын тооллогоор 228 толгой мал байгууллагын нэр дээр тоологдож 36 малын зөрүүтэй,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн нярваар дамжуулаагүй шууд зардалд бичиж зарцуулсан /Хялганат тосгоны ЭМТ 0.2,
- Жилийн эцсийн тооллогоор бараа материалын дутагдуулсан /Тэшиг сумын ЭМТ 0.2/

**2.8.5 ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 171024.9 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 179390.3 сая төгрөгөөр тайлагнагдаж тайлант онд 8365.4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь харуулбал:

Хүснэгт № 7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+	
			Бууралт-	
			тоогоор	Хувиар
Барилга байгууламж	118,611.40	128,074.80	9,463.40	68.82
Тээврийн хэрэгсэл	7,131.27	7,263.30	132.03	4.24
Машин тоног төхөөрөмж	12,910.28	13,368.10	457.82	7.68
Тавилга эд хогшил	5,945.35	5,431.20	-514.15	3.54
Зам гүүрний байгууламж	5,213.74	5,499.70	285.96	3.1
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	0.39	0.39	0.00	0
Түүх соёлын дурсгалт зүйл	1,119.01	1,104.10	-14.91	0.67
Дуусаагүй барилга байгууламж	2,155.11	235.90	-1,919.21	1.28
Номын фонд	826.11	764.9	-61.21	0.49

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Бусад үндсэн хөрөнгө	11,376.03	12,079.60	703.57	6.77
Программ хангамж	159.51	183.4	23.89	0.09
Бусад биет бус хөрөнгө	5,576.70	5,384.90	-191.80	3.32
<b>Нийт дүн</b>	<b>171,024.90</b>	<b>179,390.3</b>	<b>8,365.4</b>	<b>100.00</b>
<b>Байгууллагын ангиллаар</b>				
<b>Төсөвт байгууллага</b>	155761.0	162306.7	6,546	92.66
<b>ОНӨҮГ</b>	15263.9	17083.6	1,820	7.34
<b>ДҮН</b>	<b>171024.90</b>	<b>179390.30</b>	<b>8365.4</b>	<b>100</b>

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 96.6 хувийг биет хөрөнгө, 3.4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Өмнөх оноос барилга байгууламж 946364, тээврийн хэрэгсэл 132.0, машин тоног төхөөрөмж 457.8, зам гүүрний байгууламж 285.6, бусад үндсэн хөрөнгө 703.6 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийн 90.5 хувийг төсөвт байгууллага, 9.5 хувийг ОНӨҮГ-ын тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 20503.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний дотор төсвийн хөрөнгөөр 1551.8, хандиваар 3255.7, шилжүүлж авсан 4645.9, бүтцийн өөрчлөлтөөр 1818.4, бусад 4930.7, дахин үнэлгээний нэмэгдэл 301.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин үндсэн хөрөнгө 12125.9 сая төгрөгөөр хасагдсаны дотор худалдсан 45.9, акталсан 5496.7, шилжүүлсэн 1319.9, бусад 5052.9, дахин үнэлгээний хорогдол 210.4 сая төгрөг тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Орхон сумын ЗДТГ 174.5, Хишиг-Өндөр сумын сургуулийн 59.0, Соёлын төвийн 2.3 нийт 235.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Булган сумын 1 дүгээр сургууль үндсэн хөрөнгийн дансанд компьютер техник хэрэгслийн ашиглах жилийг буруу тооцсон, тухайлбал: 20 жилээр 11 нэр төрлийн 15558.3 мянган төгрөгийн хөрөнгийг, 10 жилээр 13 нэр төрлийн 10779.5 мянган төгрөгийн хөрөнгийг элэгдүүлсэн,
- Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд бүртгэлтэй байна. / Булган сумын 1-р сургууль 20 нэр төрлийн 13.1 сая төгрөг, Баяннуур сумын сургууль 32 нэр төрлийн 39.2 сая төгрөг, сайхан сумын сургууль 9.5 сая/
- Программ хангамж болон нярвын программыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнаагүй, ЭМГ-аас хандиваар олгосон эм эмнэлгийн хэрэгслийг орлогод аваагүй байна. /Гурванбулаг ЭМТ,/
- Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого явуулсан гэх боловч үндсэн хөрөнгийн дүнг зөрүүтэй тайлагнасан, хүнсний материалын, бичиг хэргийн тооллого хийгээгүй, тооллогын баримт дутуу, /Баяннуур сумын ЭМТ 1.4./
- Үндсэн хөрөнгийн дансны зам гүүрний ангилалд бусад үндсэн хөрөнгийг ангилан бүртгэсэн, /Хангал сумын ЭМТ 2.7 /
- Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд 11416.7 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, тавилга хэрэгсэл дансанд 1585.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй, /Баян-Агт сумын ЭМТ/
- Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, тавилга эд хогшлын тооллого хийгээгүй, тооцоо бодсон акт байхгүй, /Баян-Агт сумын ЭМТ, Тэшиг сумын ЭМТ/

## 2.8.6 Өр төлбөр

Орон нутгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4198.5 сая төгрөг байснаас тайланд онд 9195.5 сая төгрөгөөр нэмэгдэж 13394.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт № 8 Өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Арилжааны банк	38.08		-38.08	0.00
Ажилчидтай холбогдсон өглөг	53.22	52.5	-0.72	0.41
Бараа үйлчилгээний зардлын өглөг	19.54	18.9	-0.64	0.15
Татаас санхүүжилт, шилжүүлэг өглөг	1.66		-1.66	0.00
Байгууллагад төлөх өглөг	499.64	1650.0	1150.36	12.97
Хувь хүмүүст төлөх өглөг	3.46	3.9	0.44	0.03
Татварын өглөг	43.16	36.6	-6.56	0.29
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		0.03	0.03	0.00
Дансны өглөг	3.63		-3.63	0.00
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>662.39</b>	<b>1761.9</b>	<b>1099.54</b>	<b>13.85</b>
Засгийн газрын байгууллага, бусад		736.5	736.5	5.79
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	3522.74	10219.7	6697.0	80.35
Арилжааны банк	12.74		-12.7	0.00
Нөөц /өр төлбөр/ ТӨҮГ/	0.63	0.1	-0.5	0.00
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>3536.11</b>	<b>10956.3</b>	<b>7420.2</b>	<b>86.15</b>
<b>Нийт</b>	<b>4198.5</b>	<b>12718.2</b>	<b>8519.7</b>	<b>100.00</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	146.1	749.6	603.5	5.89
Төсөл сан			0	0.00
Төрийн сан	101.21	677.6	576.39	5.33
ОНӨҮГ	3951.18	11291	7339.82	88.78
	4198.5	12718.2	8519.7	100.00

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 86.1 хувь буюу 10956.3 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр, 13.8 хувь буюу 1761.9 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1775.4 сая төгрөгөөр өссөн нь “Булган Мээж” ОНӨХХК нь Дулааны станцад шилжүүлэх дулааны үнэ 767.3, аймгийн ЗДТГ 523.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн данснаас олгох нэгдсэн эмнэлгийн компьютер оношилгооны үлдэгдэл санхүүжилтийн өглөг үүссэнээс тус тус шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 3536.1 сая төгрөг, жилийн эцэст 10956.3 сая төгрөг болж өмнөх оноос 7420.2 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үлдэгдэл 3522.7 сая төгрөг нь орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн МОН-1907 төслийн хүрээнд хийгдсэн дэд бүтцийн ажлын зээлийн өглөг “Булган Мээж” ОНӨХХК-д бүртгэлтэй байна. Уг зээлийн хүүг жилд 2 удаа,

үндсэн төлбөрийг 2014 оноос эхлэн төлөхөөр гэрээнд тусгасан ч өнөөдрийг хүртэл хүү болон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Тайлант онд 7420.1 сая төгрөгөөр өссөн нь “Хот байгуулалтын салбар” МОН-2301 төслийн зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн Тэшиг сумын дулааны зуухны шинэчлэл хийгдсэнээр 736.5 сая төгрөгийн өглөгийг Тэшиг сумын ЗДТГ тайланд тусгасан байна.

Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 6696.9 сая төгрөгийн өглөгийг “Булган Мээж” ОНӨХХК бүртгэсэнтэй холбоотой өглөг өссөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Булган сумын 3-р сургууль аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/578 тушаалаар сургуулийн захирал Л.Гэрэлтуяад үр дүнгийн урамшуулал 45 хувиар олгох захирамж гарсан боловч санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй урамшуулал олгосон,
- Тайлант онд 1821.9 мянган төгрөгийн ХХОАТ өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй,
- Тооцоолсон цалинг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэж, УСНББОУС мөрдөөгүй. /Булган сумын 6-р цэцэрлэг 3.2, Бүрэгхангай цэцэрлэг 39.8, Могод цэцэрлэг 9.6, Рашаант цэцэрлэг 24.9, Сайхан цэцэрлэг 28.9/
- Хялганат тосгоны ЭМТ өмнөх оны эмийн өглөг 1126.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.

**2.8.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 133028.98 сая, эцсийн үлдэгдэл 144256.1 сая төгрөг болж, 11227.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Засгийн газрын сангийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- бууралт +/-
Засгийн газрын оруулсан капитал	55834.29	55830.5	-3.8
Өмч /төрийн/ ТӨҮГ	190.74	2417.1	2226.4
Өмч /хувийн/ ТӨҮГ	5.94		-5.9
Хөрөнгийн дахин үнэлгээ	45492.2	45541.2	49.0
Хуримтлагдсан үр дүн	31505.81	40467.3	8961.5
Дүн	133028.98	144256.1	11227.1

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Засгийн газрын оруулсан капитал дансны өөрчлөлтийн талаар:**

- “Шинэ-Хөдөө хөгжил” ОНӨААТҮГ шинээр байгуулагдсанаар 2226.4 хөрөнгийг засгийн газрын санд бүртгэсэн,

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 57 тогтоолоор эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлээс хасах тогтоол гарсантай холбоотой сумдын 12 эргэлтийн эмийн сангийн 97.7 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан,

- “Булган Мээж” ОНӨХХК-ий 28.1 сая төгрөгийн үнэлгээтэй газар, ОНХО-аар 46.0 сая төгрөгийн дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн бүртгэсэн байна.

#### **Бодлогын өөрчлөлтийн талаар:**

- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 57 тогтоолоор эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлээс хасах тогтоол гарсантай холбоотой 21.9 сая төгрөг хасагдсан,
- Аймгийн нөөцийн газар 2019 онд газрыг орлогод авахдаа 285.2 сая төгрөгийг орон андуурч бүртгэснийг залруулсан,
- Төсвийн шууд захирагч нар хөрөнгө акталсантай холбоотой 8.3 сая төгрөгийн нэмэгдсэн,
- “Хот байгуулалтын салбар” МОН-2301 төслийн зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн Тэшиг сумын дулааны зуухны шинэчлэл хийгдсэнээр 736.5 сая төгрөгийн өглөгийг Тэшиг сумын ЗДТГ тайланд тусгасан,
- Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль өмнөх онд санхүүгийн тайлан гаргаагүйгээс, тайлант онд 156.3 сая төгрөгийн алдааны залруулга хийгдсэн байна.

#### **2.9 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

#### **Аудитад хамрагдсан байгууллага, нийт алдаа зөрчил:**

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2020 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Төрийн аудитын газар 221, хараат бус аудитын компаниар 3 нийт 224 байгууллагад аудит хийхээр төлөвлөснөөс 118 байгууллагад дүгнэлт, 103 байгууллагыг түүвэрт хамруулах, 3 байгууллагад итгэл үзүүлэхээр төлөвлөн ажиллаа.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын хэлтэс, нийгмийн даатгалын нэгтгэсэн сантай нэгдсэн дүгнэлт гарахаар болсон, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Булган салбар нь ХААДС-гийн ажлын албаны бүтцэд харьяалагдан ажиллахаар болж, 2 байгууллага хасагдаж нийт 222 байгууллагад аудит хийж гүйцэтгэлээ.

Хараа бус аудитын компаниар аудит хийлгэхээр төлөвлөсөн 3 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага хийж гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдсан байгууллагаас 3 байгууллагад итгэл үзүүлэн, 103 байгууллагыг түүвэрт хамруулж, 116 байгууллагад дүгнэлт гаргаснаас зөрчилгүй 83, “Хязгаарлалттай” 27, сөрөг санал дүгнэлт 5, “татгалзсан” 1 санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 16902.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1541.5 сая төгрөгийн алдааг залруулж 121.5 сая төгрөгийн зөрчилд 123 төлбөрийн акт тогтоож, 3273.6 сая төгрөгийн зөрчилд 166 албан шаардлага, 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 11965.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 510 зөвлөмж өглөө.

#### **Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллагын талаар:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа ТЕЗ-ийн 1, ТТЗ-ийн 17, төсвийн байгууллага 162, орон нутгийн өмчит аж

ахуйн нэгж 8 нийт 188 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад итгэл үзүүлж, 98 байгууллагыг түүвэрт хамруулж, 89 байгууллагад дүгнэлт өглөө.

Үүнд: “Зөрчилгүй” 58, “Хязгаарлалттай” 26, “сөрөг санал дүгнэлт” 4, “Санал дүгнэлтээс татгалзсан” 1 тус тус санал дүгнэлт өгсөн байна.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14927.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1074.8 сая төгрөгийн алдааг залруулж, 101.8 сая төгрөгийн зөрчилд 95 төлбөрийн акт тогтоож, 2482.9 сая төгрөгийн зөрчилд 145 албан шаардлага, 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 11268.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 410 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа 17 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 17 байгууллагад зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 4984.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 355 сая төгрөгийн 14 албан шаардлага, 4629.7 сая төгрөгийн 63 зөвлөмж, сөрөг санал дүгнэлт авсан 5 эрүүл мэндийн төвийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлжээ.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Төсвийн шууд захирагчийн 162 байгууллагаас 1 байгууллагад итгэл үзүүлж, 98 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 63 байгууллагад дүгнэлт өгөхөөс “Зөрчилгүй” 37, “Хязгаарлалттай” 22, “сөрөг санал дүгнэлт” 4 өгсөн.

Аудитаар нийт 6051.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 949.3 сая төгрөгийн алдааг залруулж, 99.8 сая төгрөгийн зөрчилд 89 төлбөрийн акт тогтоож, 1834.7 сая төгрөгийн зөрчилд 115 албан шаардлага, 3167.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 304 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 8 аж ахуйн нэгж байгууллагад байгууллагад дүгнэлт өгөхөөс “зөрчилгүй” 3, “хязгаарлалттай” 4, “санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 /Илчит-Хутаг ОНӨААТҮГ /дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1734.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 125.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг зарлуулж, 2.0 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 293.1 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 1313.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 37 зөвлөмж өглөө.

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ ӨГСӨН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	№	Байгууллагын нэр
1	Булган аймгийн Булган сумын 2-р цэцэрлэг	15	Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төв
2	Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэг	16	Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв
3	Булган аймгийн Булган сумын 6-р цэцэрлэг	17	Булган аймгийн Хангал сумын Эрүүл мэндийн төв

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Булган аймгийн Булган сумын 7-р цэцэрлэг	18	Булган аймгийн Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв
5	Булган аймгийн Баян-Агт сумын Цэцэрлэг	19	Шинэ хөдөө-Хөгжил ОНӨААТҮГ
6	Булган аймгийн Баяннуур сумын Цэцэрлэг	20	Эмийн цэцэглэн
7	Булган аймгийн Бугат сумын Цэцэрлэг	21	Цоожид өрхийн эрүүл мэндийн төв
8	Булган аймгийн Бүрэгхангай сумын Цэцэрлэг	22	Аймгийн Нөөцийн газар
9	Булган аймгийн Гурванбулаг сумын Цэцэрлэг	23	Булган АЗЗА ТӨХК
10	Булган аймгийн Могод сумын Цэцэрлэг	24	Булган аймгийн ЗДТГ
11	Булган аймгийн Тэшиг сумын Цэцэрлэг	25	Булган аймгийн Бугат сумын ЗДТГ
12	Булган аймгийн Хангал сумын Цэцэрлэг	26	Булган аймгийн Сайхан сумын ЗДТГ
13	Булган аймгийн Бугат сумын Эрүүл мэндийн төв	27	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль
14	Булган аймгийн Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв		

Өмнөх онд “хязгаарлалттай санал дүгнэлт” авсан байгууллагуудаас Булган сумын 2,3,6,7 дугаар цэцэрлэгүүд, Баяннуур цэцэрлэг, Бугат сумын эрүүл мэндийн төв, аймгийн ЗДТГ гэсэн 7 байгууллага дахин хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

**2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР СӨРӨГ САНАЛ  
ДҮГНЭЛТ АВСАН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Байгууллагын нэр	Зөрчлийн утга
1	Булган аймгийн Баян-Агт сумын Эрүүл мэндийн төв	Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, тавилга эд хогшил, бусад хангамжийн материалын тооллого хийгээгүй, тооцоо бодсон акт байхгүй, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг цалингийн зардалд зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн, батлуулаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгүүлсэн, зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь малын тоо "А" дансны бүртгэл зөрүүтэй, 13 толгой малыг анхан шатны баримтгүй зарцуулсан, Эм, бэлдмэлийн зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд эмчийн эмийн захиалгын дүнгээс илүү, нярав эмнэлгийн хэрэгслийг анхан шатны баримтгүй зарлагдсан, Харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгаагүй; НБББББ-ийг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарттай нийцүүлэн батлаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.
2	Булган аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төв	Бараа материалын үлдэгдэл тооллогын дүнгээс зөрүүтэй, бараа материалын эхний үлдэгдэл эцсийн үлдэгдэл 3071.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэл 31244.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн, Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм,эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан, батлуулаагүй орон тооны ажлыг бага эмч, сувилагчид хавсран гүйцэтгүүлж цалин олгосон, харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлд заасан заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.
3	Булган аймгийн Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв	Бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодсон актгүй, тээвэр шатахууны зардлыг нөөцийн бараа дансанд бүртгэж тайлагнасан, цалингийн өглөгийг байгууллагад төлөх өглөгөөр бүртгэж дансны бичилтийг буруу хийсэн, Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 14.2, Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн; Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Булган аймгийн Тэшиг сумын Эрүүл мэндийн төв	Бараа материалын тооллого, санхүүгийн тайлангаас 7949.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, санхүүгийн тайлан дахь эмийн орлого, зарлага анхан шатны баримтаас зөрүүтэй, цалингийн зардлаас нэг удаагийн шагнал урамшууллын зардлыг зарцуулсан, эм ханган нийлүүлдэг харилцагч байгууллагуудаас 2 аж ахуй нэгжтэй тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны авлагын үлдэгдэл 1631.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, НӨАТ-ын баримтгүй эм, эмийн хэрэгсэл бэлдсэн, жилийн эцсийн бараа материалын тооллогоор 279.2 мянган төгрөгийн хүнс дутсан, бараа материалын тодруулга дахь эмийн зарцуулалтын тайлан эмийн захиалга, өдрийн түүврийн дүнгээс зөрүүтэй, Шилэн дансанд Төсөвт байгууллагын 2 дугаар сарын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.
5	Булган аймгийн Хишиг-өндөр сумын Сум дундын эмнэлэг	Бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодсон актгүй, бараа материалын эхний үлдэгдэл нярвын бараа материалын дансдын эхний үлдэгдлээс 8271.7 мянган төгрөгөөр зөрүүтэй, батлуулаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгүүлж, цалин олгосон, тендэрт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгсэл бэлдсэн, харилцагч байгууллагуудаас 2 байгууллагатай тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, шатахууны зардлыг тооцон олгохдоо холбогдох автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 541.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.

Дээрх сөрөг санал дүгнэлт авсан 5 байгууллагын холбогдох албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

**2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Олон жилийн насжилттай эзэн холбогдогч нь тодорхойгүй, найдваргүй авлагууд, сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй хуулийн байгууллагад шилжүүлсэн авлагын барагдуулалт, урт хугацаат өр төлбөрийн үндсэн болон хүүгийн төлбөрийн талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

**2.11 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Булган аймгийн Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 153 мэдээлэл байршуулахаас 107 мэдээллийг хугацаанд нь, хугацаа болоогүй 2, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан 44 мэдээлэл байна.

Шилэн дансны хуулиар хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг тухай бүр СТСХ-ын мэдээллийн самбарт байршуулан ажилласан байна.

**2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Булган аймаг дахь Төрийн аудитын газраас 12 зөвлөмж өгснөөс 11 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн нь 91.7 хувийн биелэлттэй байна.

**Өмнөх оноос дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй байна.**

1. “Төрийн сангийн нийт авлага 212.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй үүнээс 1996-2002 онуудад үүссэн хүнс, өвс тэжээл, зээл зэрэг 75.3, 2008 онд “Атрын III” аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага 137.39 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны СТА-аар өгөгдсөн боловч тодорхой ажил зохион байгуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ

аваагүй байна.” гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн, зөвлөмжийг хэрэгжилтийг хангуулахаар Шүүхэд хандсан боловч олон жилийн насжилттай хувь хүнээс болон байгууллагаас авах авлагуудын эзэн холбогдогчид нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхойгүйгээс шүүх хүлээн авах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн, найдваргүй авлагууд байна.

Зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс зөрчил дутагдлууд давтан гарсаар байна. Тухайлбал анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээг хийдэг, авлага өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, НББ-ийг холбогдох заавар, журмын дагуу хөтлөөгүйгээс бүртгэлийн алдаа, зөрчлүүд арилаагүй, давтагдан гарсаар байна.

## **2.13 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **Зөрчилгүй дүгнэлт**

Залруулагдаагүй 2157.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1696.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс үнийн дүнгийн хувьд их боловч шинж чанарын хувьд материаллаг биш, тайланд нөлөөгүй тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **2.14 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:**

### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх авлагын эхний үлдэгдэл 4200.4 сая төгрөг 2020 онд 165 иргэнд 1024.2 сая төгрөгийг зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл 4228.7 сая төгрөг үүнээс 44 хувь буюу 559 иргэн, ААНБ-тай холбоотой 1863.1 сая төгрөг нь хугацаа хэтрэлттэй байгаагаас 1390.4 сая төгрөгийн зээлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн ч удаашралтай, сангийн хөрөнгийн эргэлт, үр өгөөжийг бууруулсан байна.

**1.2 Эрсдэл:** Хууль журам зөрчигдөх, сангийн хөрөнгийн эргэлт удаашрах, найдваргүй авлага үүсэх,

**1.3 Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлийн 44 хувь буюу 1863.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг сумдын Засаг дарга нарт хариуцуулан, биелэлтийг тооцож ажиллах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан,

### **2. Авлагын данстай холбоотой холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нь “Битачи” ХХК-тай цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдан авах гэрээ байгуулан төлбөрөө төлсөн боловч гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг

хэрэгжүүлээгүйгээс 22 цэцэрлэгтэй холбоотой 176.8 сая төгрөгийн авлага үүссэн байна.

**2.2 Эрсдэл:** Хууль журам зөрчигдөх, хөрөнгө дутагдах.

**2.3 Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, СӨБ байгууллагатай холбоотой авлагыг бүрэн барагдуулах.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан,

### **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:** ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нийтлэг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээг хийдэг, авлага өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, НББ-ийг холбогдох заавар, журмын дагуу хөтлөөгүйгээс бүртгэлийн алдаа, зөрчлүүд арилаагүй, давтагдан гарсаар байна

Аудитаар нийт 14927.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1074.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 101.8 сая төгрөгийн зөрчилд 95 төлбөрийн акт тогтоож, 2482.9 сая төгрөгийн зөрчилд 145 албан шаардлага, 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 11268.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 410 зөвлөмж өглөө.

**3.2 Эрсдэл:** Хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх.

**3.3 Өгсөн зөвлөмж:** Төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалт, санхүүгийн тайлагналд гарч буй зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, бууруулахад анхаарч, өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллах.

**3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан,

### **4. Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой асуудал**

**4.1 Илрүүлэлт:** Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2019 оны А/587, 2020 оны Б/47, А/525 дугаар тушаалуудаар улсын төсвийн байгууллагуудын ТШЗ-дад урамшуулал олгохоор шийдвэрлэсэн нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1 дэх "төсвийн ерөнхийлөн захирагчийн нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**4.3 Эрсдэл:** Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

**4.3 Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1.2.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.

**4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан

### **5 Өглөгийн данстай холбоотой асуудал**

**5.1 Илрүүлэлт:** Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар төсөвт байгууллагын богино хугацаат өр төлбөр нийт 2437.8 сая төгрөгөөр тайлагнасан ба үүний 38.8 хувийг ОНӨГ-уудын өглөг эзэлж байна. Үүнээс "Булган-Мээж" ОНӨХХК нь алдагдалтай ажиллаж байгаагаас 767.3 сая төгрөгийн дулааны өртэй байна.

**5.2 Эрсдэл:** Хууль, журам зөрчигдөх, өглөг өссөнөөр төсөвт ачаалал өгөх.

**5.3 Өгсөн зөвлөмж:** Аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨҮГ-уудын үйл ажиллагаа, чадавхад үнэлэлт өгч, үр ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

**5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**6.1 Илрүүлэлт:** Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 153 мэдээллээс 44 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**6.2 Эрсдэл:** Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, хэрэглэгчид, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх.

**6.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээ мэдээллийг хугацаанд нь цахим мэдээллийн санд байршуулж ажиллах.

**6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

## АУДИТЫН ТАЙЛАНГ

### ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

### БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5.3 Өгсөн зөвлөмж:** Аймгийн ТЕЗ-ийн зүгээс ОНӨҮГ-уудын үйл ажиллагаа, чадавхад үнэлэлт өгч, үр ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

**5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**6.1 Илрүүлэлт:** Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 153 мэдээллээс 44 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**6.2 Эрсдэл:** Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, хэрэглэгчид, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх.

**6.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээ мэдээллийг хугацаанд нь цахим мэдээллийн санд байршуулж ажиллах.

**6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

### 3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,167,226.70</b>	<b>30,050,135.55</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	6,707,589.75	9,823,640.74
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	2,845.13	4,351.49
31110	Төгрөг	2,845.13	4,351.49
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	6,704,498.20	9,819,140.50
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	6,704,498.20	9,819,140.50
31211	Төрийн сангийн харилцах	6,093,481.30	9,643,106.44
31213	Арилжааны банк дахь харилцах	611,016.90	176,034.07
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	246.42	148.75
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,419,069.15	6,939,353.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,782.80	16,466.81
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,929.51	-
33400	Зээлийн хүүгийн авлага	34,057.72	28,810.15
33401	Дансны авлага /ТӨҮГ/	567.62	1,259,066.26
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	4,474.46	360.67
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5,180,426.33	5,452,818.75
3351	Байгууллагаас авах авлага	778,026.70	987,167.76
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,402,399.63	4,465,650.99
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	181,830.71	181,830.71
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	181,830.71	181,830.71
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	181,830.71	181,830.71
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	14,080.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	14,080.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7,019,346.23	13,287,141.45
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,266,157.18	1,004,350.80
35110	Тусгай зориулалттай материал	833,747.20	658,277.74
35130	Эм боох материал	432,409.97	346,073.06
35300	Бэлэн бүтээгдэхүүн	35,333.64	61,026.38

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,373,113.61	11,923,678.56
35410	Бичиг хэргийн материал	180,008.84	195,184.29
35420	Аж ахуйн материал	2,667,128.68	9,521,784.73
35430	Сэлбэг хэрэгсэл	128,358.65	130,018.27
35440	Түлш, шатах тослох материал	152,649.11	85,656.03
35450	Барилгын засварын материал	122,509.61	144,251.68
35460	Хүнсний материал	401,150.57	210,085.83
35470	Бусад хангамжийн материал	1,721,308.15	1,636,697.73
35600	Мал амьтад	344,741.80	298,085.70
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	7,141.57	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	7,141.57	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>117,961,762.14</b>	<b>126,924,209.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	117,961,762.14	126,924,209.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	112,345,858.68	121,461,152.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	118,611,448.88	128,074,811.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,125,341.85)	(35,164,787.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,131,270.15	7,263,283.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,518,148.01)	(4,489,732.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,910,284.54	13,368,085.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,600,128.23)	(5,720,865.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,945,346.98	5,431,188.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,537,045.79)	(2,491,891.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	5,213,730.05	5,499,664.30
39210	Хуримтлагдсан элэгдэл	(625,131.13)	(739,008.50)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	388.89	388.89
39212	Хуримтлагдсан элэгдэл	(239.81)	(249.54)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,119,013.17	1,104,133.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,376,034.36	12,079,552.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,536,849.69)	(3,754,235.75)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,155,113.07	235,893.58
39217	Ном	826,113.09	764,921.29
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,615,903.46	5,463,057.03
39301	Програм хангамж	159,511.95	183,440.51

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39302	Хуримтлагдсан элэгдэл	(117,882.43)	(102,249.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,576,695.06	5,384,908.48
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,421.12)	(3,042.91)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>137,128,988.84</u></b>	<b><u>156,974,345.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4,100,004.57</u></b>	<b><u>12,718,214.28</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	563,894.83	1,761,929.70
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	38,079.97	-
<b>4121</b>	<b>Төгрөг</b>	38,079.97	-
41216	Арилжааны банк	38,079.97	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	525,814.86	1,761,929.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	53,225.54	52,472.61
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,542.83	18,943.54
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	453,046.48	1,690,513.55
41361	Байгууллагад төлөх өглөг	402,792.29	1,650,017.90
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,463.70	3,894.31
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	43,164.83	36,566.30
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	-	35.04
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	3,625.66	-
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,536,109.74	10,956,284.58
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	3,536,109.74	10,956,284.58
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	3,535,482.34	10,956,148.27
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	736,500.28
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	3,522,742.92	10,219,647.99
42216	Арилжааны банк	12,739.42	-
<b>4222</b>	<b>Гадаад валют</b>	627.40	136.31
42228	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/	627.40	136.31
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>133,028,984.27</u></b>	<b><u>144,256,130.75</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	133,028,984.27	144,256,130.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,030,967.01	58,247,591.71
51101	Өмч: - төрийн	56,025,025.61	58,247,591.71
51102	- хувийн	5,941.40	-
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	31,505,813.16	40,467,335.24
51210	Өмнөх үеийн үр дүн	30,930,537.88	30,289,439.11

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

51220	Тайлант үеийн үр дүн	575,275.28	10,177,896.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,492,204.09	45,541,203.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>137,128,988.84</b>	<b>156,974,345.03</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>76,706,525.55</b>	<b>94,909,117.54</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>22,003,496.35</b>	<b>23,314,634.68</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	5,220,324.72	6,150,174.68
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	5,755,708.50	6,623,113.19
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4,303,705.94	5,005,141.57
110002	Үйл ажиллагааны орлого	171,071.49	187,317.43
110003	Хөрөнгийн орлого	578,388.07	667,770.29
110008	Шууд бус орлого	702,543.00	762,883.90
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	(535,383.78)	(472,938.51)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(535,383.78)	(472,938.51)
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	855,575.00	1,103,495.18
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	480,370.38	676,170.07
113002	Бууны албан татвар	51,316.70	50,665.06
113003	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	323,887.92	376,660.04
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	15,927,596.62	16,060,964.82
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	393,467.91	1,101,568.36
118001	Улсын тэмдэгтийн хураамж	154,036.68	242,861.63
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	91,795.15	41,771.48
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	140,567.84	162,183.07
118010	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	7,068.24	654,752.18
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	756,467.41	1,168,559.44
118101	Газрын төлбөр	756,467.41	1,168,559.44
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	14,758,246.45	13,790,837.02
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	314,679.32	381,141.77

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18,337.19	10,775.47
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	14,424,552.58	13,398,789.78
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	677.36	130.00
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	19,414.85	-
118301	Бусад татвар	19,414.85	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>45,551,202.11</b>	<b>62,276,255.40</b>
